

НЭН ЭРТНИЙ НЭГЭН ТЭМДЭГЛЭЛИЙН ТУХАЙ

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн зөвлөх профессор, шинжлэх ухааны доктор, профессор

Түлхүүр үг: Замбутив, жуулчин, аян замын тэмдэглэл, сурвалж, эртний зохиол, шашин шүтлэг, зам харгуй, өлгөмөл аргамж, бичгийн дурсгал, орчуулсан хувилбар

Монголчууд эртнээс гадаад харилцааг эрхэмлэж, төрийн хэрэг, хувийн сонирхлоор дэлхийг хэрэн бядаж явсан баялаг түүхтэй ард түмэн билээ. Тэгэж явахдаа тухайн улс орны хөгжил цэцэглэл, хүн ардынх нь аж амьдрал, соёл, зан заншил зэргийг багтаасан аян замын тэмдэглэл бичдэг уламжлалтай байжээ. Монголын их гүрний элч төлөөлөгчид Баруун Европ, Зүүн-Өмнөд Ази хүртэл зорчиж, аян замын тэмдэглэл бичиж үлдээсний нэгэн дурсгал нь Елүй Чу Цайн «Баруун тийш аялсан тэмдэглэл» мөн. Түүнээс гадна Ромын Пап, Францын хаан, Английн ванд тус тус бараалхсан монгол элч Бар Саумын перс хэлээр бичсэн тэмдэглэл, Жанжаа хутагт, Зая хамба нарын зэрэг мэргэд Хятадын Бээжин, Жэхээ, Төвдийн Лхас хотуудад зорчсон тухай сонирхолтой тэмдэглэлүүд, Сүмбэ хамба Ишбалжирын 1777 онд бичсэн «Замбутивийг ерөнхийлөн

номлогч үгс», XIX зууны үед Чойжиданзанпэрэнлэйн бичсэн «Өмнөх замбутивийн байр байцыг дэлгэр номлосон тодорхой толь», мөн үед Жамбадоржийн бичсэн «Болор толь», нэлээд хожуу буюу XX зууны хориод оны дунд үед И.Амгалангийн бичсэн «Цастын орныг зориод Цайдамын Монголд саатсан нь» гэх мэт олон дурсгалыг нэрлэж болно.

Монголд аян замын тэмдэглэл үүсэхэд Энэтхэг, Хятадын нийтлэлийн утга зохиолын нөлөө их байжээ. Түүний нэг баталгаа нь эртний Хятадын нэрт жуулчин Фа Сианы бичиж үлдээсэн «Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг» гэдэг аян замын тэмдэглэл юм. Уг тэмдэглэл тухайн цагтаа Ази, Дорно дахин төдийгүй Европ тивд дэлгэрч байсан боловч XIX зууны эхний хагаст Буриадын эрдэмтэн Банзарын Доржийн франц хэлнээс орчуулсан хувилбар бидэнд уламжилжээ. Тэрхүү орчуулгын нэг нь Казань хотын номын санд, нөгөө нь Польшийн эрдэмтэн Ковалевскийн номын санд байсан бөгөөд дээрх хоёр хотод түймэр гарахад устсан гэж үзэж байв. Гэтэл Банзарын Доржийн тэр орчуулгыг тэр үеийн бичиг үсэгтэй монгол

хүмүүс сонирхон үзэж худам монгол бичгээр хуулж авсан байжээ¹.

Ар Монгол нутагт хагас зуун жил хадгалагдаж байсан тэр бичгийг 1921 онд Монгол улсын Судар бичгийн хүрээлэн байгуулж ховор ном зохиол цуглуулах явцад уг хүрээлэнгийн номын сан хөмрөгт бүртгэж авсан ажээ. Эртний Хятадын жуулчны тэмдэглэл монгол, буриад газарт бий гэсэн сургийг хожим Судар бичгийн хүрээлэнгийн анхны гишүүдийн нэг болсон Гэлэгжамц (номын нэр нь Буяндалай) гэдэг төвд, монгол бичигтэй лам дуулаад уйгагүй эрж хайсны дүнд Банзарын Доржийн багш Нэхийтийн Галсан гэдэг эрдэмтэй ламын садан төрлийн хүн болох зайсан Цэвэгжав Сампил гэгчийн үр садаас олж авсан байна. Тэр хуулбараас Зава Дамдин бас нэг хувь хуулуулж аваад тухайн үеийн номын гол хэл болж байсан төвд хэл рүү хөрвүүлсэн гэдэг мэдээ бий. Буяндалайн олж авсан хуулбар нь орос цаасан дээр буриад бичээчийн тэгээр бичсэн хувь байсан бөгөөд уг хуулбар эх «1927-1937 он хүртэл Судар бичгийн хүрээлэнгийн номын санд байсан»² гэж академич Б.Ринчен тэмдэглэсэн байдаг. Тэр хуулбар өнөөдөр сураггүй болсон байна. Үүний зэрэгцээ Зава Дамдин өөрийн хуулуулж авсан хувийг мөн Судар бичгийн хүрээлэнд хадгалуулахаар Жамъян гүнд өгснийг 1924 онд Гарсай гэдэг хүн Улсын номын сангийн ховор номын дансыг үйлдэхдээ уг хуулбар эхийг хавтаслаж «Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг» гэдэг нэрийг гадна нүүрэн дээр нь бичиж хадгалсан байна. Тэр бичгийг 1970 онд академич Б.Ринчен судалгааны өмнөх үгтэйгээр гэрэл зургийн

аргаар төвд, худам монгол бичгээр хадмаллан хэвлүүлсэн нь эдүгээ бидний барьж байгаа бичгийн цаасны хэмжээтэй, хөх хавтастай нимгэн ном болно.

Түүнчилэн Банзарын Доржийн орчуулсан хуулбар Алайр аймгийн нэгэн бичгийн сурвалжит айлд байсныг профессор Поппе 1928 оны үесд олж үзээд ихэд сонирхон хуулж авсны дээр гучаад оны сүүлчээр Ленинград хотноо хэвлэлд бэлтгэж байсан мэдээ байдаг боловч дэлхийн дайн дэгдсэнтэй холбоотойгоор хэвлүүлж амжаагүй бололтой. Б.Ринчен гуайн таамаглаж бичсэнээр Поппегийн үзсэн «Алайр аймгийн тэр айлын номын шүүгээнээс Доржийн орчуулгын бас нэг хувь гарч болзошгүй бөгөөд Казань, Варшав хоёрт галын гамшигт үрэгдсэн хувиас гадна, Байгалын хойт биеийн буриад дунд лавдуу нэг хувь хуулбар, Доржийн төрсөн нутагт дор хаяхад хоёр хувь, манай Улаанбаатарт хоёр хувь, жич: Заваа Дамдины монголоос нь төвд болгосон хэдэн хувь байсны нэгийг нь Гандантэгчинлэн хийдийн хамба Эрдэнэпил гавж агсны бие түүх сонирхдог хүн байсан учир гуч гаруй жилийн өмнө үзэж байсан тэр хувь»-ийг оролцуулаад уг тэмдэглэлийн бардаагаар есөн хувь хуулбар байсан тухай тэмдэглээд, тэдгээрийн ганц нэг нь ч гэсэн эдүгээгийн автономит Буриадын Сэлэнгэ дагуу нутагтай айлын номын санд, ялангуяа булгад овогтны бичигтэн өтгөсийн номын авдар шүүгээнээс олдож болох юм гэсэн байдаг.

Үүнээс үзвэл Фа Сианы тэмдэглэл нэгэн цагт монгол, буриад газарт нэлээд тархсан бөгөөд одоо ч эрж сурахад илүүдэхгүй аж.

Уг тэмдэглэл хэдийгээр Монголын тухай биш ч гэсэн бидний сонирхон судалваас зохих бүтээлийн нэг яриангүй мөн. Юуны өмнө энэ тэмдэглэл нь Дорно дахинд зохиогдож эдүгээ хүртэл уламжилсан эртний зохиолын нэг болно. Түүнчилэн энэ зохиол нь Дорно дахины, түүний дотор Монголын бичгийн мэргэдэд аян замын тэмдэглэл бичих үлгэр дуурайлал болсоор ирсэн байна. Дэлхийн олон улсын эрдэмтэн, жуулчдын аян замын тэмдэглэл бичиж ирсэн арга барилыг өнгөц боловч сонирхож үзэхэд үндсэн хоёр тэгийг мөрдөж ирсэн бололтой байдаг. Тэр тэгийг Өрнийн, Дорнын хэмээн ангилж болно. Өрнө дахины аян замын тэмдэглэлийн зохиогчид алс газар зорчиж явах замд тохиолдсон хамгийн сонирхолтой үйл явдал, хэн хүнд хэрэгтэй чухал мэдлэг ухаан, арга барилын зүйлийг сорчлон авч бичдэг бөгөөд нэгэнт хэрэгтэй гэснийг түүж бичдэг учраас үйл явдлын болсон дарааллыг төдийлөн баримталдаггүй байна.

Гэтэл Дорно дахины бичгийн мэргэд аялал хэдийнээс хэдий хүртэл, хаанаас хаана хүртэл үргэлжилсэн дарааллыг хатуу баримталж, явсан сууснаа өдөр сар, газар нутгийн нэр устай нь хамт тэмдэглэхийн зэрэгцээ, зам зуурт тохиолдсон газар нутгийн байдал, хүн ардын ахуй амьдрал, уулзсан хүмүүсийн үг яриа зэргийг гээлгүй бичдэг уламжлалтай байна.

XIII-XX зууны эхэн үе хүртэлх хугацаанд монгол хүний бичсэн цөөнгүй тэмдэглэл бидний үед хүрч ирсэн юм. Сонирхож судлууштай нэг зүйл бол тэдгээр замын тэмдэглэлүүд одоогоос 1500 гаруй жилийн өмнө

бичигдсэн Фа Сианы тэмдэглэлийн тэг арга барилаар бичигдсэн явдал мөн. Фа Сиан жуулчны бичсэн «Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг» хэмээх тэмдэглэлийн тухай багашаархан өгүүлэл бичих болсны учир бол уг тэмдэглэлийн түүхэн баримт сэлт, хэл найруулга, үгсийн сан, өгүүлэх ур маяг зэргийг өнөөгийн хүрсэн түвшинтэй харьцуулан судлахад чухал хэрэглэгдэхүүн болж байгаад оршино.

Фа Сиан «Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг» хэмээх аян замын тэмдэглэлээ V зууны үе буюу Хун Ши хааны хоёрдугаар онд Энэтхэгийн орнуудад шашин ном дэлгэрсэн байдлыг биеэр үзэхээр хэсэг нөхдийн хамт зорчсон тухайгаа нийт дөчин бүлэг болгон бичсэн байна. Тэрбээр тэмдэглэлийнхээ эхэнд жуулчлах болсон үндсэн шалтгаанаа тодруулж «Чан ань-д байхдаа гурван аймаг савгүй болж, судруудаар дутуу болон эвдэрснийг үзээд сэтгэл эмээж бүрэн тэрхүү учраар аян замд шуударсан» гэсэн байдаг. Нэн эрт цагт бичигдсэн тэрхүү тэмдэглэлийн байдлыг танилцуулах зорилгоор зарим нэг хэсгээс нь товч боловч толилуулъя.

Фа Сиан тэмдэглэлийнхээ эхэнд «Хун Ши хааны хоёрдугаар онд Ху Хинь, Дү Ян, Ху Ин тэргүүтэн, бас бус олон нөхөд найраар явж Энэтхэг орноо ном ба шашны тогтоолуудыг бадраан мөрдмүй. Тэд Цань Аниас мордоод Лүн хэмээх уулыг давж, Ци Яньхуй хэмээх орон хүрч зогсон амраад, урагшаа явж Эл Ниу Тан хэмээх оронд хүрч ирсэн хойно Ян Лу уулыг даваад Цань Яа хэмээх цэргийн аймагт хүрсэн бөлгөө» гэж очсон газраа дарааллаар нь тоочсон байна. Дээр дурдсанаас үзвэл

зам харилцаа төдий л хөгжөөгүй, өнөөгийнх шиг авто болон агаарын тээвэргүй байсан тэр үед алс газар аялаар явагсад элдэв дээрэм тонуулаас сэрэмжлэхийн тулд олуулаа явдаг, бас зам зуурт өлсөж, даарахаас болгоомжлон хоол хүнс, хучлага дэвсгэр зэргээс эхлээд ихээхэн ач барааг ердийн хөсгөөр тээвэрлэж олон сар жилээр явдаг байсныг мэдэж болохоор байна. Тэмдэглэлд бас ямар хүмүүстэй уулзаж учирснаа илтгэж «Тэр цагт Цань Яа газар улам самуун явдал гарснаар зам явж болохгүй болсон бөлгөө. Цань Яагийн хаан нь тэднийг хайрлан өршөөх сэтгэлээр байлгаж, өглөгийн эзэн болой. Тэрхүү цагт Ци Яньхуйн Сань Шибу Юн, Сан Хин ба бас бус лам нар лугаа учрав. Адил нэгэн үйлд зорьж явдал учралдсандаа баясаад хамт суув. Сууж дууссаны хойно тэдгээр лүгээ хамтаар мордоод Дүн Хуанд хүрэв. Тэр орон хэмээвээс дорноос өрнө зүгт нэгний газар, өмнөөс умар зүгт дөчний газрын төдий орон амой» гэхчилэн бичсэн байна.

Тэмдэглэлийн хоёрдугаар бүлэгт «Шиан Шань хэмээх орон нь уулархаг бүсэд овгор товгор газар буй. Шороо нь хүчгүй бөгөөд үргүй буй. Улсын ван хийгээд хувцас нь цалан, Нанхиад улсад адил боловч гагцхүү эсгий ба торго эдлэхэд ялгавар буй. Энэ орны хаан шашинтай буй. Түүний газар доор дөрвөн мянган хуврагууд бөгөөд бүгдээр бага хөлгөний ном сурмой. Лам харгүй цөм Энэтхэгийн шашин шүтэх боловч, нарийн ба нарийн бус номлоход ялгавартай» гэх мэтээр газар нутаг, хөрс ургамал, хүн ардын зан заншил, шашин шүтлэг зэргийг нэгбүрчлэн тоочиж бичсэн байна. Мөн

энэ тэмдэглэлээс тэр үед өнөөгийн Энэтхэг улсын нутаг дээр тавь гаруй жижиг улс оршиж байсан бөгөөд, тэдгээр улс цөм тус тусдаа хэлтэй байсныг «Орон бүрт бусдаас ялгавар харь нэгэн хэл баймой» гэснээс мэдэж болно.

Зохиогч номынхоо «Хутагын орон» гэсэн гуравдугаар бүлэгт: «Хутагын орон хэмээвээс жаргалант болоод дэлгэрч байхуй орон амой. Иргэнд нь элдэв юм элбэг дэлбэг, хамаг ард нь бүгдээр номд шүтдэг бөгөөд тэр номоор тэднийг жаргалант болгож, тэр орон дахь хэдэн түмэн хуврагуудаас олон нь Их хөлгөнийг шүтмүй. Цаваа бүгдээр хамт зоогломуй. Тэдгээр ард одыг үзэж гэрээ барьдаг бөгөөд гэр бүрийн үүдний тус бяцхан суврагыг босгож, бага хэмээсэн нь хорин тохой шахуу өндөр буй»³ гэсэн бол, «Чүн лин хэмээх уул, мөнх байгч цасан, умрын Энэтхэг орон» гэсэн зургаадугаар бүлэгт: «Майдар бодисатвагийн шүтээн Хэвэй шин-гийн орноос өрнө зүгт Энэтхэгийн умар биеийг зорьж мордоод Чүн лин уулыг давахдаа нэг сар замд явав. Эдгээр уулын орой дээр өвөл, зунгүй цас баймой. Идэшгүйдээ хороо гаргадаг могойнууд буй амой. Салхи хур цасыг хийсгэсэн элс өнхрүүлсэн чулуунуудаар замын улсад маш их тотгортой болохуй тул түмэн хүн алж тэнд одвоос нэг нь ч үл гармой. Тэр газрын ардыг цаст уулын улс хэмээмой. Тэр хөвч даваад умард Энэтхэгийн газарт хүрнэ. Тэр газарт одвоос Туй ли хэмээх нэгэн бяцхан хан орон баймой. Тэнд цөмөөр Бага хөлгөний маш олон хуврагууд буй амой» гэжээ. Мөн «Шин тэй мөрөн» хэмээх долдугаар бүлэгт: «Хөвч уул

аяар дагаж өмнө, өрнийн зүгт арван таван хоног явав. Тэр зам нь маш хэцүү болоод хүнд тотгор хийгээд аймшигтай халил газар дүүрэн амой. Тэдгээр уулсад найман мянган тохой өндөр бөгөөд хэрэм мэт хавцгайгаас өөр олон юм үгүй. Дэргэд нь ирэхэд хүнийг халгаах мэт буй. Явж явтал хөл халтирваас барьж тогтоох юм огт үгүй буй. Дорно Шин тэй хэмээх мөрөн амой. Эртний улс зам харгуйн тул хадыг тас огтлоод долоон зуун гишгүүрт шат цавчиж хийсэн ажгуу. Тэрхүү шатаар буугаад өлгөмөл аргамжаар мөрнийг гаталмой. Мөрний хоёр эргийн хоорондох ан нь наян алхмын төдий буй.

Зан Хин ба Хэн Ин хоёр нь эд улсын үед явахдаа нэг нь ч энэ газар хүрсэнгүй бөлгөө. Тэдний явдлыг гадаад хэргийн яамны хэлмэрч түшмэл бичсэн амой» гэжээ. Дээрх ишлэлээс үзэхэд Энэтхэгт V зуунаас эрт үед уул хадыг сэтлэн шаталсан зам тавьж, гол мөрөн дээгүүр дүүжин гүүр байгуулж чаддаг байжээ. Хамгийн сонирхолтой нь бид Фа Сиан жуулчны энэхүү тэмдэглэлийг их эртнийх хэмээн олзуурхан тэмдэглэж байтал түүнээс үлэмж түрүүнд Хятадын хоёр жуулчин Энэтхэгт аялсан тухай тэмдэглэл бичигдсэнийг мэдэж авсан явдал болно. Бас тэр үед Гадаад хэргийн яам ажиллаж, хэлмэрч нарыг зардаг байсан нь Хятад орон нэн эрт үеэс гадаад харилцааг эрхэмлэн хөгжүүлж байсныг харуулж байна.

Фа Сианы тэмдэглэл эртний занш-лаар нэлээд том хэмжээтэй бичигдсэн бөгөөд түүний дотор тоочлого, хүүрнэл, уран дүрслэл, харилцан яриа зэрэг өгүүлэмжийн олон арга хэлбэрийг ашигласан байхын дээр домог, үлгэр, зохиогчийн сэтгэгдэл зэрэг аман болон бичгийн утга зохиолын төрөл, зүйлийг ашигласан газар ч олон тааралдана.

«

Фа Сианы тэмдэглэл дотор тоочлого, хүүрнэл, уран дүрслэл, харилцан яриа зэрэг өгүүлэмжийн олон арга хэлбэрийг ашигласан байхын дээр домог, үлгэр, зохиогчийн сэтгэгдэл зэрэг аман болон бичгийн утга зохиолын төрөл, зүйлийг ашигласан газар ч олон тааралдана.

»

Миний нярваан болсноос хойно энэ орноо нэг нэрт хаан төрж, энэ газар суварга байгуулах больюу хэмээсэн ажгуу. Хойно нэг хаан ертөнцөд төрөөд замд уртаад тэр орноор явтал нь тэнгэрийн хаан хурмаст түүнээ санаа төрүүлэхийн тулд нэгэн залуу үхэрч хүмүүний дүрээр хувилаад зам дээр нь нэгэн суварга барьж байв. Хаан бээр түүнийг ихэд сайшаагаад, тэр малчны барьсан суваргаас өөр нэгийг бариулсан ажгуу. Тэр суварга нь дөчин ян-аас илүүгүй өндөр, элдэв эрднэсээр чимсэн тул хэн үзсэн бүхэн суварга ба сүмийн үзэсгэлэн, жавхланг гайхмой. Тэр суваргыг нь замбутивийн хамаг суваргуудаас эрхэм хэмээн сонсогдсон бөлгөө» гэх буюу «Бурханы бадар аяга тэр оронд буй. Эрт цагт Юа Шийн

хаан нь аугаа хүчит цэрэг дуудаад тэр орныг довтолж Шигмуний бадар аягыг эзэлсүгэй хэмээсэн ажгуу. Тийн эрхэндээ оруулсны хойно Юуа Ши хаан нь номд маш их биширдэг тул тэр аягыг аваад залж одсугай хэмээснээр тахилыг бэлтгээд гурван эрдэнээр тахил өргөсний хойно сайхнаар чимсэн их зааныг авч ирээд аягыг түүний дээр тавьсанд заан газар унаад явж эс чадав. Тантача дөрвөн тэрэг хийгээд түүний аягыг тавьж, найман заанд татуулбаас тун нэг алхам урагш явж эс чадав. Хаан нь аягын заяа хэрэгтэй ажгуу хэмээн ухаад итгэлээ ихэд эмээвч тэр орноо нэгэн суварга ба нэгэн хийд бариулаад түүнийг тахихын тул нэгэн хэсэг цэрэг байлгаад элдэв зүйлийн ёслолыг бүтээлгэв» гэжээ. Энэ мэт домог сонирхлын зүйл Фа Сианы тэмдэглэлд олон бий.

Мөн тэмдэглэлийн арван дөрөвдүгээр бүлэгт «Өвлийн хоёр сард Ба Этиянь тэргүүтэн бус нөхөд нь цаст бяцхан уулсаас өмнө зүгт гатлав. Тэр орны өмнө этгээдэд хүйтэн маш их. Тийн болбоос Хуй Хинг хүйтэн сэрүүнийг тэсч ядан урагшаа явах чадал нь алдармой. Амнаасаа хөөс гаргаад Этиянь өгүүлрүүн: Би амьдрахгүй байнам. Та даруй явагтун. Бид цөмөөр үхэхийн хэрэггүй» хэмээн хэлсэн тухай өгүүлсэн нь эртний бичиг зохиолд байдаг харилцан ярианы хэлбэрийг агуулсан байна. Энэ мэт судалгаа шинжилгээний ажилд санаа сэдэл болохуйц зүйл арвин бий.

Энэ мэтээс үзэхэд Фа Сианы алдарт тэмдэглэл өнөөдөр ч хуучраагүй бөгөөд танин мэдэхүйн ач холбогдол нь хадгалагдсаар амой. Гэтэл энэ үнэт бүтээлийг манай сэтгүүлчид төдийлөн сонирхож

судлахгүй байна. Тэр тусмаа сэтгүүл зүйн түүх, туурвилын төрөл зүйлийг сонирхон судлагч залуу нөхөд, эртний бичиг зохиолын хэл өөрчлөгдөн хувьссаар өнөөгийн бичиг зохиолын хэлэнд хүрч ирсэн байдлыг харьцуулан судлах хүмүүс, бас сэтгүүлчийн эрдэмд суралцаж байгаа оюутан сурагчдад нэн чухал хэрэглэгдэхүүн болох нь зайлбаргүй.

Ишлэл

¹ Шофман А. С. 1956. Казанский период жизни и деятельности Доржи Банзарова. Бурят-монгольское книжное изд-во. М., с. 43.

² Ринчен Б. 1970. Оршил. Фа Сиан жуулчны тэмдэглэл. УБ., 3 дахь тал.

³ Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 88-89 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.

2. Фа Сиан. 1970. Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг. (Хуучин монгол, төвд бичгээр) УБ.

3. Хүрэлбаатар Л. 1999. Олон хэлт монгол утга зохиол. (Монголын соёлын түүх). Дэд боть. УБ.

4. Бира Ш. 1960. Монгольская тибето-язычная историческая литература (XVII-XIX вв). УБ.

5. Владимирцов Б. Я. 1920. Монгольская литература (Литература Востока). Вып. 2. Петербург.

6. Кара Д. 1972. Книги монгольских кочевников. УБ.

Summary

This article is about the itinerary by Fa Cian, an ancient Chinese tourist, who wrote it when he traveled India. It explores about how this itinerary, which was written 1500 years ago, was inherited and I also expressed my opinion on its value and example.